

## «НУУЦ ТОВЧОО»-Г ХЯТАДАД СУДАЛСАН НЬ

Г. Гунгаа

**1. Эртний судлал.** Хятадад 200 гаруй жилийн тэртээгээс «Нууц товчоо»-г судлах ажил эхэлсэн бөгөөд гадаадын бусад орнуудад «Нууц товчоо»-г судалсан судалгаа нь 100 гаруй жилийн түүхтэй юм.

Монголын үндэстний эртний түүхийн бүтээлүүдэд ихэнхдээ уран зохиолын үнэ цэнэ хадгалагдсан байдаг. Тухайлбал: «Монголын нууц товчоо»-ны уран зохиолын үнэ цэнэ нэн их юм. «Нууц товчоо» бол эртний монголчуудын бичиж туурвисан бүтээлүүдийн дээж нь билээ. «Нууц товчоо»-ны 282-р бүлэгт дурьдсанаар «их хуралдаан хурж байхад, хулгана жилийн хуран (7 сард) Хэрлэнгийн хөдөө арлын Долоон болдог, Шилхэнцэг хоёрын завсар хааны орд буух дор бичиж дүүргэв» гэснийг дэлхийн ихэнх судлаачид 1240 онд бичиж дуусгасан гэж үздэг.

«Нууц товчоо»-г төрөлхийн авьяас билэг бүрдсэн, гарамгай түүхч, уран зохиолч Монгол хүн бичиж туурвисан гэдэг нь маргаангүй юм.

«Нууц товчоо»-ны эх бичиг нь одоо хир олддоогүй байгаа бөгөөд хятадаар галиглан орчуулсан нь олон улс оронд янз бүрээр хэвлэгдсээр байна. «Нууц товчоо»-ны хятадаар галигласан орчуулгыг Мин улсын үед Хун ү-гийн 1368-1398 онд Сартуулын Хуюоанжи, Уйгурын Машайхэй нар ордонд хадгалагдаж байсан Монгол эхээс хятад хэлнээ орчуулаад тухайн үедээ түүнийг Монгол хэл сурах хичээлийн сурах бичгийн зориулалтаар хэвлэн нийтэлсэн байна.

Дараа нь Мин улсын Юн Лөгийн (1403 он) үед Юн ле да дянь гэдэг номд «Нууц товчоо»-г бүрэн эхээр нь оруулжээ. 1848 онд Жан Му, Хө Чютао нар «Нууц товчоо»-ны бас нэг орчуулгыг хийсэн гэдэг.

Хятадын түүхчид дотроос нууц товчоог судалсан эрдэмтдийг дурьдвал: Жан Му, Хө Чютао, Шүй Сун, Ли Вэньтянь, Чэнь Биньхө, Е Дө хуй, Гү Гуанчи, Хун Жүнь, Шэн Зэнжи, Чян Дашинь, Ше Зайшан, Алтан-Очир Бөххишиг, Дугаржав, Хишигбат нарын зэрэг хүмүүс нууц товчооны тайлбар ба орчуулгын талаар судлан нягтлах ажлыг хийжээ.

**2. Орчин үеийн судлалд.** БНХАУ байгуулагдсанаас хойш «Нууц товчоо»-г судлах талаар нэлээд ажил хийж байна. Нууц товчоог судлах дугуйлан (Хөх хотод) байгуулаад ажиллаж байна. (Дугуйлангийн захирал нь Хөх хотын багшийн дээд сургуулийн захирал Баяр) Тус дугуйлангаас эрхлэн «Нууц товчоо»-ны талаар 5000 гаруй ном, өгүүлэл бичсэн гэдэг бүртгэл гаргаад байна. Үүний зарим нэг материалаас дурьдвал: Элдэнтэй, Оюундалай, Асралт нарын бичсэн «Монголын нууц товчооны тайлбар» гэдэг номд «дөрвөн бүлэгт цувралын 3-рт Гү Гуанчи 1805 онд төгсгөлийн үг бичиж оруулсан «Монголын нууц товчоо»-ны эхийг Е Дөхүй, Чянь Дашинь нарын бичсэн хоёр эхтэй харьцуулан, эх бичигт байгаа янз бүрийн алдаа мэдгийг «Монголын нууц товчоо»-ны зүйл зүйлээр нь хүснэгтлэн харуулаад нийтдээ 3000 гаруй алдаа мадаг байгааг дурьджээ. Энэ бол «нууц товчоо»-ны судлалд гарч байгаа шинэ бөгөөд томоохон хувь нэмэр юм.

Баярын бичсэн «Монголын нууц товчоо» гэдэг номд «Монголын нууц товчоо»-ны хятад үсгийн жинхэнэ галиг эхийг үг тус бүрийн

арын хятад орчуулгатай нь хамт тавиад ард нь латинаар галигласан монгол эх, өөрийн нэхэн сэргээсэн ХШ зууны монгол эх, орчин үеийн монгол хэлээрх орчуулгыг нийтлүүлжээ. Зүйл бүрийн ард нь тэр үеийн хятад товч орчуулгыг хавсаргажээ. Баяр зохиолдоо дэлгэрэнгүй удиртгал бичиж, зохиолынхоо эцэст нь «Монголын нууц товчоо»-г галиглахад хэрэглэсэн 520 хятад үсгийн эртний дуудлага, хятадын олон аялгууны дуудлага, Монголоор галиглахад хэрэглэсэн жишээ дурьдсан «авианы толь» оруулжээ.

Булгийн бичсэн «Монголын нууц товчооны үндэстний хэлбэр» гэдэг номд сэдвийн тольт (үндэс), «Нууц товчоо»-ны шинж, «Монголын нууц товчооны үндэстний хэлбэр хэлбэржин тогтсон түүхэн тавилан», «Монголын нууц товчооны үндэстний хэлбэр», «Монголын нууц товчооны үндэстний хэлбэрийн бичгийн зохиолд үзүүлсэн нөлөө» гэх мэт 5 бүлгээр бичихдээ монгол, хятад сурвалж зэрэг 70 гаруй зохиол ашиглажээ. Булаг энэ номдоо «Нууц товчоо»-ны чухам ямар зүйл нь «Хураангуй алтан товч», «Лувсанданзангийн «Алтан товч» зэрэгт байгааг дурьдаад «Монголын нууц товчоо»-ны яруу найргийг 9 зүйлд хувааж хавсаргах зэргээр шинэ зүйл нэлээд хийжээ. Элдэнтэй, Оюундалай нарын бичсэн «Монголын нууц товчоо»-ны харгуулан хянасан дэвтэр гэдэг номд зохиогчид товч оршил бичээд, «Монголын нууц товчоо»-г орчин цагийн монгол хэлээр буулгаад, цөөн тооны тайлбар хийжээ. Номын сүүлд монголын хаадын удмыг бичиж ашигласан 17 номын жагсаалт хавсаргажээ

Мансааны бичсэн «Шинээр орчуулж тайлбарласан Монголын нууц товчоо» гэдэг номд нууц товчоог орчин цагийн монгол хэлээр орчуулаад, нэлээд олон тайлбар хийж, номын сүүлд хүний нэр, овог аймгийн нэр, газрын нэрийн жагсаалт, толь хийж хэвлүүлжээ. Ийм жагсаалтыг Япон зэрэг оронд хийсэн боловч нууц товчоог орчин цагийн монгол хэлээр нэлээд тайлбартай хийсний хувьд «Нууц товчоо»-ны судлалд энэ нь чухал хувь нэмэр болох бүтээл юм. Юй Дажүнь өөрийнхөө бичсэн «Нууц товчооны бичсэн оныг магадласан нь» гэдэг өгүүлэлдээ: «Нууц товчоо»-г их хуралдаан болж, хулгана жилийн (1240) хуран (долдугаар) сард Хэрлэнгийн хөдөө арлын Долоон болдог, Шилхэнцэг хоёрын завсар хааны орд бууж байхад бичиж төгсөв гэдэг асуудлын хувь эрдэмтдийн санал зөрөөтэй байдаг тухай дэлгэрэнгүй дурьдаад, 1228, 1240, 1252, 1264 оны аль нэг онд их хуралдаан хурсан тэр жил бичиж дуусгасан гэдэг нь зөв бөгөөд их хуралдаан жил бүр болдоггүй байсан. Өгөөдэй хааны үед их хуралдаан зөвхөн хоёр удаа болсон байх бөгөөд тэр их хуралдаа нь 1240 онд болоогүй байна гэдэг санал дэвшүүлжээ.

Хятадын нийгмийн шинжлэх ухааны академийн утга зохиолын хүрээлэнгээс 1983 онд хэвлүүлсэн «Хятадын цөөн тоот үндэстний уран зохиол» гэдэг номын дэд дэвтэрт дурьдахдаа: «Нууц товчоо»-ны бичвэрүүдийг нэгтгэн үзвэл хүмүүсийн яриа ба харилцан яриа нь ихэнхдээ шүлэглэх байдалтай байгаагаас гадна бүлэг бүрт өдий төдий бадаг шүлэг орсон байна. «Нууц товчоо»-нд орсон аман зохиолын ба яруу найраг, ерөөл, магтаал, зүйр цэцэн үг зэргээс үзвэл Монгол үндэстний урлагийн баялаг сан хөмрөг нэгэнт бий болчихсон үед уг зохиолыг бичсэн «Товчоо»-ны Чингис хааны удмаас үе улирч ирсэн удмын угсааны сургамж, Монгол үндэстний феодалын ноёрхогч ангийнхнаас гаднын хүмүүст танилцуулахыг хориглосон дотоодын бичиг байсан, «Товчоон»-нд тэр үеийн феодал язгууртны хэрэг явдлыг үнэн байдлаар дүрслэн бичсэн, тэр үеийн бүх хэрэг явдлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлсон, өөрийн үр ач нарыг эв нэгдэлтэй байж, нэгдэж нягтрахыг сургамжилсан, «Товчоо» нь эхнээсээ аваад адгаа хүртэл

эртний үг, эцэг өвгөдийн сургаал захиасыг үндэслэн хойт үеийн үр ач нартаа хагарал бутралгүй эв нэгдэлтэй явахыг захиж сургасан, эртний монголын ард түмний амьд үг хэллэг, бичлэгийн өндөр түвшинд газар дэлхий доргисон түүхэн үе, нийгмийн ээдрээтэй амьдралыг үнэн бодитой, баялаг гүнзгийгээр тусган харуулсан, нүүдэлчин аймгуудыг нэгтгэснийг тод томруун дүрсэлсэн, Монгол үндэстний феодалын үеийн эзэн Чингис хааны баатарлаг дүрийг бүтээснээс гадна, Чингис хааныг хүрээлэн буй 100 гаруй баатрын дүрийг дүрсэлсэн зэргийг дэлгэрэнгүй дурьджээ. Энэ бүтээлийн гол ач холбогдол нь «товчоо»-нд сэргэн мандсан тулгар төрийг бат бэх байлгах гэсэн санаа зорилготойгоос гадна «Нууц товчоо» гэдэг нэрний «Нууц» гэсний учрыг тайлбарлан, тэр үеийн ноёд, язгууртнуудын гарал үүсэл, хаан ширээнд гарах хүртлээ хийж байсан хэрэг явдлууд, тэр үеийн нийгмийн байдлыг үнэн байдлаар дүрсэлсэн тул, нийтэд тараах, гаднын хүнд танилцуулахыг хориглож, ордонд ганцхан хувь хадгалж байсан тул «Нууц товчоо» гэж нэрлэсэн гэдэг санааг батлах, баримт материал бүрдүүлснээрээ «Нууц товчоо»-ны орчин үеийн судлалд ач холбогдолтой юм. Орчин үед «Нууц товчоо»-г судлах талаар БНХАУ-д нэлээд ажил хийж байгаа бөгөөд «Нууц товчоо»-ны талаар судалгаа хийдэг хүмүүсийг дурьдвал: Цай Мэйбяо, Юй Дажүнь, Дорнотив, Оюундалай, Асралт, Баяр, Мансаан, Элдэнтэй, Адшаажав, Чингэлтэй, Булаг Дугаржав нарын зэрэг эрдэмтэн, судлаачид байна.

**«МОНГОЛЫН НУУЦ  
ТОВЧОО» ДАХЬ АРДЫН  
АМАН ЗОХИОЛЫН  
СУДАЛГАА**

— Бодончирын морины сүүл богино байгаагийн шалтгаан

Х. Хасуми

### 1. Бүлэг

«Монголын нууц товчоо» (Цашид МНТ гэж бичье)-ны 24-р зүйлд дараахь өгүүлэл бий. Энд раквилцын ром үсгээр буулгасныг тэр чигээр авья<sup>1</sup>

Boduncar uruq-a ese to' a (q) daju e (n) de atala ya' un ke' eju qol da' aritu qodoli se' ultu oroq-singqula-yi unuju ükü' esü inu üküsgеi a' asu inu asuqai ke' eju onan-müren huru' u yorciju talbiba yorciju baljun ara (1) gürcü tende ebesun nembüle ger kijü tende aba sa' uba

Энд миний хөндөх асуудал бол дээр иш татсан зүйлийн доогуур зурсан хэсэг юм. Энэ талаар Мураками, Ц.Дамдинсүрэн хоёрын оруулгыг дор сийрүүлье.

#### 1. Муракамигийн орчуулга<sup>2</sup>

24. Бодончир урагт тоологдохгүй атал энд юу хийж сууна гээд «Гол дайрт годил сүүлт» хар шинхул мориндоо мордож «үхэх юм бол үхье, амьдрах юм бол амьдаръя» гэж Онон голыг уруудан давхиж одов.

Удалгүй Балжийн аралд хүрч, тэндээ өвсөн дээвэртэй гэр хийж амьдран суув.